



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн
аудит

Аудитын код: СЭА-2022/255-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363047	Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn
------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12-13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14-15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15-16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.10 Өмнөх оны албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18-20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХМХА	Хилийн мэргэжлийн хяналтын алба
ХЧТА	Хөдөлмөрийн чадвар түр алдалт



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022-02-25 № 00А - 2022/255-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-г

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ГААЛИЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б. ӨНӨБОЛД ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	204,072,868.74	272,958,832.22
33	АВЛАГА	0.00	535,047.44
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	535,047.44
35	БАРАА МАТЕРИАЛ	204,072,868.74	272,423,784.78
35100	Түүхий эд материал	107,077.77	416,452.77
35110	Тусгай зориулалттай материал	107,077.77	416,452.77
35300	Бэлэн бүтээгдэхүүн	24,306,442.86	1,598,300.00
35400	Хангамжийн материал	179,659,348.11	270,409,032.01
35410	Бичиг хэргийн материал	6,095,629.62	5,218,410.69
35420	Аж ахуйн материал	173,563,711.78	265,190,004.41
35440	Түлш, шатах тослох материал	6.71	616.91
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	140,713,704.99	310,240,306.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	140,713,704.99	310,240,306.94
39200	Биет хөрөнгө	135,721,704.99	305,248,306.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	48,485,900.21	150,608,977.21
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8,376,764.66	-15,766,264.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	97,963,287.50	126,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-94,104,740.13	-30,630,532.05
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,037,645,799.63	984,285,973.63
39206	Хуримтлагдсан элэгдэл	-950,338,645.81	-920,696,671.41
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,869,121.90	10,503,729.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,422,253.65	-6,956,904.80
39214	Бусад үндсэн хөрөнгө	0.00	7,000,000.00
39300	Биет бус хөрөнгө	4,992,000.00	4,992,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,692,000.00	4,692,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	344,786,573.73	583,199,139.16
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	217,934.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	217,934.00
41300	Өглөг	0.00	217,934.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	217,934.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	344,786,573.73	582,981,205.16
51	Засгийн газрын хувь оролцоо	344,786,573.73	582,981,205.16
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	224,849,785.98	224,849,785.98
51200	Хуримтлагдсан үр дүн	114,976,877.04	353,171,508.47
51210	Өмнөх үеийн үр дүн	-32,121,785.44	114,976,877.04
51220	Тайлант үеийн үр дүн	147,098,662.48	238,194,631.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,959,910.71	4,959,910.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	344,786,573.73	583,199,139.16

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,752,416,706.62	1,879,703,434.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	314,070,706.62	415,496,934.00
120	Нийтлэг татварын бус орлого	314,070,706.62	206,473,857.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	39,369,211.00	166,115,937.00

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,369,211.00	36,999,487.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	129,116,450.00
120009	Бусад орлого	0.00	40,357,920.00
121	Хөрөнгийн орлого	0.00	106,900,000.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	0.00	106,900,000.00
122	Тусламжийн орлого	0.00	102,123,077.00
122001	Хандив тусламж /дотоод/	0.00	102,123,077.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,438,346,000.00	1,464,206,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,343,042,000.00	1,418,790,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,343,042,000.00	1,418,790,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	95,304,000.00	45,416,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	57,400,000.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,904,000.00	44,416,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,605,318,044.14	1,641,508,802.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,605,318,044.14	1,641,508,802.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,402,458,912.22	1,434,491,882.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	847,648,292.28	836,065,696.49
210101	Үндсэн цалин	608,586,413.00	557,320,906.34
210102	Нэмэгдэл	198,983,079.28	213,662,789.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,078,800.00	65,082,001.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,940,267.80	113,358,723.35
210201	Тэтгэврийн даатгал	79,771,460.34	79,196,916.03
210202	Тэтгэмжийн даатгал	8,161,521.96	8,831,866.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,117,228.55	6,783,253.02
210204	Ажилгүйдлийн даатгал	3,177,401.25	1,686,062.51
210205	Эрүүл мэндийн даатгал	16,712,655.70	16,860,625.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,598,310.00	26,957,114.74
210301	Гэрэл, цахилгаан	2,372,610.00	2,881,534.98
210302	Түлш, халаалт	14,607,184.00	14,755,595.16
210303	Цэвэр, бохир ус	1,048,516.00	2,019,884.60
210304	Байрны түрээс	2,570,000.00	7,300,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	86,143,445.08	114,645,300.54
210401	Бичиг хэрэг	23,603,324.80	21,647,709.80
210402	Тээвэр, шатахуун	36,655,482.28	37,353,789.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,927,109.00	18,281,490.94
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,957,529.00	37,362,310.00
2105	Нормативт зардал	18,792,210.00	41,796,552.76
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,332,210.00	16,905,850.00
210502	Хоол, хүнс	1,460,000.00	750,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	24,140,202.76
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	222,945,958.00	223,294,921.60
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	3,405,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	206,612,308.00	193,128,021.60
210604	Урсгал засвар	16,333,650.00	26,761,900.00
2107	Томилолт, зочны зардал	8,919,500.00	1,881,600.00
210702	Дотоод албан томилолт	8,919,500.00	1,881,600.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,052,200.00	23,635,498.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,328,300.00	18,423,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	760,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,000.00	306,850.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,400.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	480,500.00	659,550.00
210807	Газрын төлбөр	0.00	269,798.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,841,000.00	3,160,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,418,729.06	52,856,475.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	360,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	79,418,729.06	52,496,475.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	202,859,131.92	207,016,920.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,442,500.00	46,900,687.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,892,500.00	41,877,384.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45,550,000.00	5,023,303.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	89,122,631.92	122,360,233.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,143,420.92	30,028,386.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,110,000.00	6,660,000.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	33,869,211.00	85,671,847.04
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	40,294,000.00	37,756,000.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	34,794,000.00	37,756,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	147,098,662.48	238,194,631.43
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	147,098,662.48	238,194,631.43

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,477,715,211.00	1,501,423,921.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,369,211.00	37,217,421.00
120	Нийтлэг татварын бус орлого	39,369,211.00	37,217,421.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	39,369,211.00	37,217,421.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,369,211.00	37,217,421.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,438,346,000.00	1,464,206,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,343,042,000.00	1,418,790,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,343,042,000.00	1,418,790,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	95,304,000.00	45,416,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,904,000.00	44,416,000.00

II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,475,015,211.00	1,488,423,921.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,475,015,211.00	1,488,423,921.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,272,156,079.08	1,281,189,066.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	847,648,292.28	836,065,696.49
210101	Үндсэн цалин	608,678,850.00	557,320,906.34
210102	Нэмэгдэл	198,890,642.28	213,662,789.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,078,800.00	65,082,001.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,940,267.80	113,675,836.79
210201	Тэтгэврийн даатгал	79,771,463.34	79,514,029.47
210202	Тэтгэмжийн даатгал	8,161,521.96	8,831,866.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,117,228.55	6,783,253.02
210204	Ажилгүйдлийн даатгал	3,177,401.25	1,686,062.52
210205	Эрүүл мэндийн даатгал	16,712,652.70	16,860,625.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,598,310.00	25,128,714.74
210301	Гэрэл, цахилгаан	4,210,042.00	2,881,534.98
210302	Түлш, халаалт	12,769,752.00	14,755,595.06
210303	Цэвэр, бохир ус	1,048,516.00	2,019,884.70
210304	Байрны түрээс	2,570,000.00	5,471,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	80,031,409.00	75,361,090.94
210401	Бичиг хэрэг	15,684,900.00	14,460,800.00
210402	Тээвэр, шатахуун	36,654,400.00	37,354,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,927,109.00	18,281,490.94
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,765,000.00	5,264,400.00
2105	Нормативт зардал	72,739,800.00	56,791,930.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	66,909,800.00	51,649,430.00
210502	Хоол, хүнс	1,460,000.00	750,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,370,000.00	4,392,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	122,007,600.00	147,389,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	103,528,000.00	120,027,800.00
210604	Урсгал засвар	14,719,600.00	27,361,900.00
2107	Томилот, зочны зардал	8,919,500.00	1,881,600.00
210702	Дотоод албан томилолт	8,919,500.00	1,881,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,270,900.00	24,534,498.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,328,300.00	18,423,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	760,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,000.00	306,850.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,400.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	480,500.00	659,550.00
210807	Газрын төлбөр	0.00	269,798.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,059,700.00	4,059,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	360,000.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	360,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	202,859,131.92	207,234,854.04
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	30,028,386.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	30,028,386.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,442,500.00	46,900,687.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,892,500.00	41,877,384.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45,550,000.00	5,023,303.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	89,122,631.92	92,549,781.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,143,420.92	78,918,680.04
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,110,000.00	6,660,000.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	33,869,211.00	6,971,101.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	40,294,000.00	37,756,000.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	34,794,000.00	37,756,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,700,000.00	13,000,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,000,000.00	13,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,000,000.00	13,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,000,000.00	13,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,000,000.00	13,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,000,000.00	-13,000,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	224,849,785.98	4,959,910.71	-32,121,785.44	197,687,911.25
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	224,849,785.98	4,959,910.71	-32,121,785.44	197,687,911.25
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	147,098,662.48	147,098,662.48
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	224,849,785.98	4,959,910.71	114,976,877.04	344,786,573.73
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	224,849,785.98	4,959,910.71	114,976,877.04	344,786,573.73
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	224,849,785.98	4,959,910.71	114,976,877.04	344,786,573.73
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	238,194,631.43	238,194,631.43
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	224,849,785.98	4,959,910.71	353,171,508.47	582,981,205.16

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,418,790,500.00	1,340,089,753.96	78,700,746.04	94.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,418,790,500.00	1,340,089,753.96	78,700,746.04	94.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,372,762,500.00	1,294,189,066.96	78,573,433.04	94.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	885,080,200.00	836,065,696.49	49,014,503.51	94.46
210101	Үндсэн цалин	541,683,700.00	557,320,906.34	-	102.89
210102	Нэмэгдэл	257,483,500.00	213,662,789.07	43,820,710.93	82.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	67,493,000.00	65,082,001.08	2,410,998.92	96.43
210104	Урамшуулал	18,420,000.00	0	18,420,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,485,800.00	113,675,836.79	5,809,963.21	95.14
210201	Тэтгэврийн даатгал	84,082,600.00	79,514,029.47	4,568,570.53	94.57
210202	Тэтгэмжийн даатгал	8,850,800.00	8,831,866.24	18,933.76	99.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,080,600.00	6,783,253.02	297,346.98	95.80
210204	Ажилгүйдлийн даатгал	1,770,200.00	1,686,062.52	84,137.48	95.25
210205	Эрүүл мэндийн даатгал	17,701,600.00	16,860,625.54	840,974.46	95.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,906,200.00	25,128,714.74	777,485.26	97.00
210301	Гэрэл, цахилгаан	3,259,000.00	2,881,534.98	377,465.02	88.42
210302	Түлш, халаалт	15,926,500.00	14,755,595.06	1,170,904.94	92.65
210303	Цэвэр, бохир ус	1,249,000.00	2,019,884.70	-770,884.70	161.72
210304	Байрны түрээс	5,471,700.00	5,471,700.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	75,607,700.00	75,361,090.94	246,609.06	99.67
210401	Бичиг хэрэг	14,460,800.00	14,460,800.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	37,354,400.00	37,354,400.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,528,100.00	18,281,490.94	246,609.06	98.67
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,264,400.00	5,264,400.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	74,806,100.00	56,791,930.00	18,014,170.00	75.92
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	68,918,500.00	51,649,430.00	17,269,070.00	74.94
210502	Хоол, хүнс	1,495,600.00	750,500.00	745,100.00	50.18
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,392,000.00	4,392,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	160,389,700.00	160,389,700.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	13,000,000.00	0.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	120,027,800.00	120,027,800.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	27,361,900.00	27,361,900.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,881,600.00	1,881,600.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	1,881,600.00	1,881,600.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,245,200.00	24,534,498.00	4,710,702.00	83.89

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,095,900.00	18,423,600.00	4,672,300.00	79.77
210803	Даатгалын үйлчилгээ	760,000.00	760,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	325,000.00	306,850.00	18,150.00	94.42
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	55,000.00	15,000.00	78.57
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	659,600.00	659,550.00	50.00	99.99
210807	Газрын төлбөр	275,000.00	269,798.00	5,202.00	98.11
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,059,700.00	4,059,700.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	360,000.00	360,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	360,000.00	360,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,028,000.00	45,900,687.00	127,313.00	99.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,028,000.00	45,900,687.00	127,313.00	99.72
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,878,000.00	41,877,384.00	616.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,150,000.00	4,023,303.00	126,697.00	96.95
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,418,790,500.00	1,340,323,753.96	78,466,746.04	94.47
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,418,790,500.00	1,340,323,753.96	78,466,746.04	94.47
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,418,790,500.00	1,340,323,753.96	78,466,746.04	94.47
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	73	62	11	84.93
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	56	45	11	80.36
620003	Үйлчлэх ажилтан	16	16	0	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	73	62	11	84.93
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	57	46	11	80.70
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16	16	0	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,416,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,416,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,416,000.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	6,660,000.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	37,756,000.00

I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	45,416,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,416,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	44,416,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар боомт дахь ХМХА-ны /цаашид Сүхбаатар боомт дахь ХМХА гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэх, өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийг үндэслэж, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд хяналт тавих, төлбөр тооцоо, гүйлгээг гарахаас өмнө нь хянан баталгаажуулж байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар боомт дахь ХМХА нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулийг сахиулан, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх, хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, бизнес эрхлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хилийн хорио цээрийн хяналт,
- Хилийн эрүүл ахуйн хяналт,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,

- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэж байна.

Тус албаны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг МХЕГ-аас 2016 онд баталсан бөгөөд түүнд тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс болон шууд захирагчийн тусгайлсан санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар боомт дахь ХМХА нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,605,318.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 24,079.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 18,059.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар боомт дахь ХМХА-ны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 244,270.8 мянган төгрөгөөр буюу 70.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө			
Авлага	0	535,0	535.00
Урьдчилгаа			
Бараа материал	204,072.90	272,423.80	68,350.90
Үндсэн хөрөнгө	140,713.70	310,240.30	169,526.60
Нийт хөрөнгө	344,786.60	583,199.10	238,412.50
Өр төлбөр		217.9	217.90
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	344,786.60	582,981.20	238,194.60
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	344,786.60	583,199.10	238,412.50

Бараа материалын дансны үлдэгдэл 272,423.8 мянган төгрөг болж 68,350.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 225,744.1 мянган төгрөгийн материал худалдан авсан болон МХЕГ-аас 3,827.4 мянган төгрөгийн үнэт цаас, 36,413.0 мянган төгрөгийн нормын хувцас, Ковид-19 цар тахалтай холбоотой 80,875.2 мянган төгрөгийн 1 удаагийн хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, 8,313.4 мянган төгрөгийн багаж, хэрэгсэл аймгийн Онцгой комиссоос 40,357.9 мянган төгрөгийн бараа материалыг тус тус үнэ төлбөргүй хүлээн авч, 327,180.1 мянган төгрөгийн материал зарцуулсан зэргээс шалтгаалсан байна. Бараа материалын дансны үлдэгдэлд он дамжсан, ашиглалтгүй хөрөнгө байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,284,290.7 мянган төгрөг болж 70,334.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 13,000.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан болон МХЕГ-аас 102,123.1 мянган төгрөгийн ариутгалын пункт, 106,900.0 мянган төгрөгийн 2 автомашинуудыг үнэ төлбөргүй хүлээн авч, ТӨБЗГ-ын 10 дугаар сарын 19-ний өдрийн 469 дүгээр тогтоолоор 151,688.5 мянган төгрөгийн хөрөнгө акталсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 582,981.2 мянган төгрөг болж 238,194.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Тус газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 127,286.7 мянган төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлого өссөнөөс голлон шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 36,190.7 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар өссөн нь тайлант онд 2 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарсантай холбоотойгоор тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,745,041.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 391,992.6 мянган төгрөгөөр бууруулж, 1,353,048.6 мянган төгрөгөөр батлагдсан байна.

Тайлант онд батлагдсан төсөвт 1 удаа өөрчлөлт оруулж, 2021 оны 12-р сард 65,741.9 мянган төгрөгөөр өсгөн, 1,418,790.5 мянган төгрөгөөр эцэслэн баталсан нь томилолтын зардлын хэмнэлтээс урсгал засварт 16,892.3 мянган төгрөг шилжүүлж, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хөдөлмөр хамгааллын хэрэглэлд 48,849.6 мянган төгрөг нэмж баталсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,418,790.5 мянган төгрөгийн орлого төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,418,790.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,340,089.8 мянган төгрөгийг зарцуулан, 78,700.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,340,089.8 мянган төгрөг буюу 94.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 49,014.5 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 5,809.9 мянган төгрөгөөр, байр ашиглалтай холбоотой тогтмол зардлыг 777.5 мянган төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардлыг 246.6 мянган төгрөгөөр, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг 17,269.0 мянган төгрөгөөр, хоол, хүнсний зардлыг 745.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 4,710.7 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг 127.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Дээрх зардлуудаас голлон хэмнэгдсэн цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын хэмнэлт нь батлагдсан орон тоо дутуу ажилласантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,000.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон гэрчилгээ, торгуулийн төлбөрийн нэмэлт орлогоос 44,416.0 мянган төгрөг, нийт 45,416.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урамшууллын зардалд 1,000.0 мянган төгрөгийг зарцуулж, туслах үйл ажиллагааны орлого 44,416.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх чиг үүргийг гаалийн байгууллагад шилжүүлсэнтэй холбогдуулан Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албыг татан буулгах шийдвэр гарсан байна.

3.7.2 Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т *“Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг **улсын төсөвт үйлдвэрийн газар** гэнэ”*, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан *“Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 3.1-д “Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаанд дараах хугацааг оруулан тооцно” 3.1.4: “Улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, захиргааны ажилтан, бусад ажилтнаар 1996 оны 8 дугаар сарын 1-нээс 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хүртэл ажилласан хугацаа”* гэж зохицуулсан байдаг.

Гэтэл өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Эрдэнэцолмонгийн Увс аймгийн Усны аж ахуйн барилга угсралтын трестэд ажиллаж байсан 7 жилийн хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцож, буцалтгүй тусламж олгохоор МХЕГ-аас хянаж, ирүүлсний дагуу нийт 15,664.1 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Дээр дурдсан Увс аймгийн Усны аж ахуйн барилга угсралтын трест нь улсын төсөвт үйлдвэрийн газар мөн эсэх талаарх эрсдэл үүсгэж байгаа учир төрийн албанд ажилласан хугацааг үнэн зөв тодорхойлж, тэтгэмж олгох нь зүйтэй гэж үзэж байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд тус алба нь мэдээлбэл зохих 20 төрлийн 119 мэдээллээс 3 мэдээллийг / төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайлан / хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх оны албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,267.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөгдсөнөөс нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, ажиллах, шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлэх гэсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

/мянган төгрөг /

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	2	5,267.2	2	5,267.2	100
Зөвлөмж	2		-		-
Нийт дүн	4	5,267.2	2	5,267.2	50

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан Алтанбулаг боомтод шинээр нэмэгдсэн 102,123.0 мянган төгрөгийн ариутгалын пунктыг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.



4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 83,193.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 26,406.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 56,786.9 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 3 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаанаас үүссэн дараах ажил гүйлгээг аудитын явцад илрүүлж, санхүүгийн тайланд залруулга хийлгэв. Үүнд:

- Төлбөр тооцоог урьдчилан хянаагүй, цалинг зөрүүтэй тооцоолсны улмаас 31 албан хаагчид нийт 5,687.8 мянган төгрөгийн нэмэгдэл цалинг илүү тооцож, олгосныг аудитын явцад нөхөн суутгуулав.
- Тайлант онд нягтлан бодогч, нярав нарт улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 651.0 мянган төгрөг урамшуулал цалинг илүү олгосныг аудитын явцад нөхөн төлүүлж, залруулав.
- Тайлант онд нийгмийн даатгалын сангаас олгосон 217.9 мянган төгрөгийн ХЧТА-ы тэтгэмжийг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан,
- Тайланд онд гарсан 10,000.0 мянган төгрөгийн бохир шугамын засварыг зардалд тайлагналгүйгээр барилгын өртгийг капиталжуулсан,
- Тайлант онд худалдан авсан 7,000.0 мянган төгрөгийн контейнерыг орлого авахдаа данс буруу ангилж бүртгэсэн,
- Тайланд онд худалдан авсан 1,849.6 мянган төгрөгийн бичиг хэрэг, хангамжийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэсэн,
- Мөнгөн гүйлгээний тайланд 1,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалтыг зардлаар тайлагнасныг биет, биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тайлагнуулав.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1.1 *Илрүүлэлт:* Тайлант онд 44,318.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

1.2.1 Илрүүлэлт: Тус байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж буй автомашинуудын засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлд 11,933.9 мянган төгрөг зарцуулсан боловч байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-өөс уг засвар үйлчилгээг зайлшгүй хийх шаардлагатай эсэхийг тогтоож, хэлэлцэж шийдвэрлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Автомашинны сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2.2 Өгсөн зөвлөмж: Цаашид автомашины эвдрэл гэмтлийг анхан шатны баримтаар нотлох, өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийг үндэслэж, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд хяналт тавих.

2. Төлбөр тооцоотой холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас тайлант онд 317.1 мянган төгрөгийн НДШ-ийн авлага, 217.9 мянган төгрөгийн ХЧТА-ы тэтгэмжийн өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Төлбөр тооцоо, гүйлгээг гарахаас өмнө нь хянан баталгаажуулж байх, авлага, өр төлбөрийг 2022 оны төсөвт суутган тооцох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүхбаатар боомт дахь ХМХА	10	83,193.2	7	26,406.3					3	56,786.9